



БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 08 сарын 05

Залаа

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**1.1 Орлоготой иргэн**

- 1.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж үйлдвэрлэл эрхлэгчдэд дамжуулан бага хүүтэй зээл олгоно.
- 1.2 Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.
- 1.3 Өрхийн оёдлын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.4 Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.5 Хүн амын хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ.

**1.2 Эрүүл иргэн**

- 1.2.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг эзэмшүүлэх чиглэлээр “Сургалтын төв” байгуулна.
- 1.2.2 Ахмадын эрүүл мэндийг дэмжиж, эмчилгээний дараах болон уламжлалт эмчилгээ, сувилгаа, нөхөн сэргээх төрөлжсөн тусламж үйлчилгээний төв /эмнэлэг/ байгуулна.
- 1.2.3 Эрүүл мэндийн оношилгооны чадавхыг дээшлүүлж, эмч мэргэжилтнийг нарийн мэргэжлээр бэлтгэн, иргэн бүр бүрэн эрүүл мэндийн үзлэг оношилгоонд жил бүр заавал хамрагдах тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.2.4 Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, орон нутгийн оношилгоо мэдээллийг дээд шатлалын эмнэлгүүдтэй цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.2.5 Эрүүл мэндийн төвийг орчин үеийн шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.

**1.3 Чанартай боловсрол**

- 1.3.1 Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.2 Иргэдийн эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.3.3 Хувь хүн, гэр бүл, байгууллагын соёлыг төлөвшүүлэх бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.

000000001



- 1.3.4 Дотуур байрны их засварыг хийж стандарт шаардлагад нийцүүлэн ашиглана.
- 1.3.5 Сургалтад шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана.

#### 1.4 Тогтвортой - Амар амгалан гэр бүл

- 1.4.1 Зорилтод бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулж, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 1.4.2 Хувь хүн, гэр бүлтэй ажиллах хүний нөөцийг бэлтгэж, тогтвор суурьшилтай ажиллуулна.
- 1.4.3 Гэр бүл дэх эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг боловсронгуй болгох бодлогыг хэрэгжүүлнэ.

#### 1.5 Хүүхэд хамгаалал хөгжлийн чиглэлээр

- 1.5.1 Хүүхэд хамгаалал, төлөвшлийг сайжруулах орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.2 Хүүхдийн хүчирхийлэл, осол гэмтлээс хамгаалах олон талт арга хэмжээг зохион байгуулна.
- 1.5.3 Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж хүүхэд олноор зорчих гудамж, зам талбайг гэрэлтүүлэх, хурд сааруулагч хийж камержуулна.
- 1.5.4 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж хүүхдэд аюулгүй орчныг бүрдүүлнэ.

#### 1.6 Залуучуудыг дэмжих чиглэлээр

- 1.6.1 Залуучуудын хөгжил төлөвшлийг сайжруулж, нийгмийн оролцоог нэмэгдүүлж, идэвхтэй амьдралыг дэмжинэ.
- 1.6.2 Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг сайжруулж, хөнгөлөлт эдлүүлэн хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.6.3 Ахмадын зөвлөх үйлчилгээг салбар бүрт хэрэгжүүлнэ.
- 1.6.4 Соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулж, дэмжлэг үзүүлнэ.
- 1.6.5 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх чиглэлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.6.6 Монголын үндэсний баяр наадам, үндэсний спортын язгуур шинжийг хадгалан уламжлуулж, сурталчилан таниулах, үндэсний спортын наадмыг жил бүр зохион байгуулна.
- 1.6.7 Шинэ соёлын төвийг тоног төхөөрөмжөөр хангаж, гадна тохижилтыг хийхэд дэмжлэг үзүүлнэ.

### ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1.1 Орон нутгийн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, орлогын бүрдүүлэлтийг сайжруулж, санхүүгийн алдаа зөрчлийг бууруулах, салбарын боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлж төсвийн ил тод байдлыг хангана.

000000002

*[Handwritten signature]*



71435  
167 90

2.1.2 Иргэн, айл өрх бүр хуримтлал үүсгэн эдийн засгийн хямралд өртөхөөс сэргийлж “Хуримтлалтай Шинэжинстчүүд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.3 Хорио цээрийн дэглэм бүхий махны үйлдвэр байгуулна.

2.1.4 Арьс, нэхий элдэх үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ.

2.1.5 Ингэний сүү боловсруулах бага оврын үйлдвэр байгуулна.

## 2.2 Дэд бүтэц

2.2.1 Гэр хорооллын айл өрхүүдийг био жорлонгоор хангаж хөрсний бохирдлыг бууруулна.

2.2.2 Төвийн гудамж, талбайг камержуулан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.

2.2.3 Сумын төвийн тоосжилтыг бууруулж 2 км авто зам барина. Баянхонгор-Шинэжинст сумыг холбосон автозамын чиглэл, трассыг батлуулж санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэн, ажлыг эхлүүлнэ.

2.2.4 Стандартын шаардлага хангасан нисэх онгоцны аэродром байгуулна.

2.2.5 Эхийн голын төвийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.

## ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1 Төрийн албаны шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгч, хяналт тавих боломжийг бүрдүүлэх цахим системийг нэвтрүүлнэ.

3.2 Төрийн үйлчилгээг операторын үйлчилгээнд шилжүүлж, үйл ажиллагааг нь тогтмолжуулж чанаржуулна.

3.3 Сумын нутгийн удирдлагын ордон шинээр барьж ашиглалтад оруулна.

3.4 Гамшигт үзэгдлүүд /ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга г.м/-ийн тархалт, давтамж, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын судалгааг хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлж, зохих нөөцийг бүрдүүлнэ.

3.5 Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн болзошгүй байдалд зориулалттай эрсдэлийн санг байгуулж, иргэдийн боловсролыг дээшлүүлнэ.

## ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1 Бэлчээрийг нөхөн сэргээх малчдын дундын сан байгуулна.

4.2 Цаг уурын шинжилгээний станцын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.

4.3 Малын бэлчээр тэлэх зорилго бүхий газруудад худаг уст цэг гаргах, цас, бороо, мөсний хаялбарыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах усны нэмэлт эх үүсвэр бий болгоно.

4.4 Мод тариалах аяныг чанартай зохион байгуулж нутгийн модлог ургамлыг тарималжуулна.

4.5 Бичил уурхайтай холбоотой асуудлыг цэгцэлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, бичил уурхайчдад ээлтэй бодлого боловсруулж бичил уурхайчдаа дэмжинэ.

## ТАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ

5.1 Малыг эрүүл байлгах, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж, ашиг шимийг нэмэгдүүлж гений санг хамгаална.

000000003

*[Handwritten signature]*



- 5.2 Нутгийн шилмэл үүлдрийн малыг өсгөн, эдийн засгийн эргэлтэд оруулж, тааварлаг чанарыг сайжруулна.
- 5.3 Эхийн голын услалтын системийн хүчин чадлыг нэмэгдүүлж, атаршсан талбайд жимс жимсгэнэ, төмс хүнсний ногоо тариална.
- 5.4 Малчин өрх бүр өөрийн хэрэгцээний тэжээлийн ургамлыг тариалж тэжээлийн нөөц бүрдүүлж, эрсдэлээс хамгаалах чадамжийг бий болгоно.

МЭДЭЭЛЛИЙГ БИЧСЭН  
ШИНЭЖИНСТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫГ ТӨЛӨӨЛЖ  
ДЭД ДАРГА Д.ГОТОВДОРЖ



*Handwritten signatures and initials*

000000004



Handwritten red mark resembling a stylized '3' or '5'.